

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн
77 дугаар тогтоолын 8 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Эдийн засаг, хөгжлийн яам

Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн
бодлогын газрын Шинжлэх ухааны
бодлого, төлөвлөлтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Шинжлэх ухааны бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Эрхэлсэн түшмэл, ТЗ-3

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI
байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлт, төрөөс баримтлах бодлого, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө болон түүнд хамаарах хууль тогтоомж, эрх зүйн орчин, үндэсний судалгаа хөгжүүлэлтийн болон шинжлэх ухаан, технологийн төсөл хөтөлбөрийн нэгдсэн бодлого төлөвлөлт, менежментийг боловсронгуй болгох, хэрэгжилт, зохицуулалтыг нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах, холбогдох арга хэмжээг мэргэжлийн түвшинд зохион байгуулж гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, төрөөс баримтлах бодлого, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө болон түүнд хамаарах хууль тогтоомж, эрх зүйн орчин, холбогдох дүрэм, журмын нэгдсэн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, зохицуулалтыг хангах;
- 2.Үндэсний болон шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын нэгдсэн бодлого, төлөвлөлтийг сайжруулах бодлого, төлөвлөлтийг хийх, удирдлага, зохицуулалтаар хангах;
- 3.Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын тогтолцоог сайжруулах талаар бодлогын санал боловсруулах, хэрэгжилт, зохицуулалтыг хангах;
- 4.Шинжлэх ухаан, технологийн удирдлагын болон мэдээллийн нэгдсэн сангийн бодлого шийдвэрийг тодорхойлох, нээлттэй шинжлэх ухааныг хөгжүүлэх ажлыг бодлогын түвшинд нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;
- 5.Төсөл хөтөлбөрийн нэгдсэн бодлого, төлөвлөлт болон шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөрийн бодлого, төлөвлөлт, арга аргачлалыг тодорхойлж, шийдвэрийн санал, төсөл боловсруулж, хэрэгжилтийг хангах, үр дүн гүйцэтгэлд хяналт тавих;
- 6.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, төрөөс баримтлах бодлого, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө болон түүнд хамаарах хууль тогтоомжийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан хөгжүүлэх, санал боловсруулах, салбарын менежмент, тогтолцоог боловсронгуй болгох, сайжруулах;	Салбарын менежмент, стратеги төлөвлөлт, тогтолцоо бүрдсэн байна.	Г, Х
	2.Шинжлэх ухаан, технологийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, үйл ажиллагааны хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, боловсронгуй болгох санал боловсруулах;	Салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	3.Шинжлэх ухаан, технологийн гадаад, дотоод орчинд дүн шинжилгээ хийх, салбарын хөгжлийн чиг хандлагыг тогтоох ажлыг удирдлага, зохион	Салбарын хууль тогтоомж, бодлого, эрх зүйн орчны төлөв байдал, цаашдын бодлого зураглал,	Г, Х



	байгуулалтаар хангах, үр дүнг бодлого, шийдвэрт тусгах санал боловсруулах.	төлөвлөлтөд дүн шинжилгээ, судалгаа хийгдсэн байдал, түүнийг салбарын бодлого, шийдвэр, саналд тусгасан байна.	
2 дугаар зорилтын хүрээнд	1.Үндэсний болон шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай нэгдсэн бодлого, төлөвлөлтийг сайжруулах бодлогын санал боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;	Судалгаа хөгжүүлэлтийн ажлын чанар хүртээмж сайжирч, бодлого төлөвлөлт хангагдсан байна.	Г,Х,Т
	2.Эрдэм шинжилгээний ажлын ерөнхий хүрээ, зураглал, үндсэн чиглэлийг тодорхойлох ажлыг нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах, бодлогын дэмжлэг үзүүлэх;	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ерөнхий хүрээ, зураглал, үндсэн чиглэлийг тодорхойлсон байна.	Г,Х,Т
	3.Үндэсний болон шинжлэх ухаан, технологийн салбарын судалгаа хөгжүүлэлтийн ажлын үндсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох арга хэмжээг удирдлага, зохицуулалтаар хангах.	Салбарын судалгаа хөгжүүлэлтийн ажлын үндсэн шаардлага, шалгуур олон улсын стандартад нийцсэн байна.	Г,Х,Т
3 дугаар зорилтын хүрээнд	1.Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийн тогтолцоог сайжруулах хууль эрх зүйн орчныг судлах, бодлого төлөвлөлтийг сайжруулах санал боловсруулах;	Салбарын санхүүжилтийн тогтолцоо бүрдсэн байна.	Г, Х
	2.Салбар /шинжлэх ухаан, технологи/-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн саналыг нэгтгэн боловсруулах;	Төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдэлд салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын санал боловсруулж, тусгасан байна.	Г, Х, Т
	3.Салбар /шинжлэх ухаан, технологи/-ын төсөв санхүүжилт, хөрөнгө оруулалтын хуваарилалтын үр ашгийг дээшлүүлэхэд	Санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр зорилтот түвшинд хүргэх зорилт	




	шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх ;	дэвшүүлж, хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Т
	4.Хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх процессын зураглалд үнэлэлт дүгнэлт өгөх, сайжруулах саналыг боловсруулах, хэрэгжилтийг хангахад удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.	Шинжлэх ухаан, технологийн салбарын төслийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх процесс хангагдсан байна.	Г, Х, Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Шинжлэх ухаан, технологийн удирдлагын болон мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх бодлого шийдвэрийг тодорхойлох;	Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн байна.	Г, Х, Т
	2.Нээлттэй шинжлэх ухааныг хөгжүүлэх ажлыг бодлогын түвшинд нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;	Нээлттэй шинжлэх ухааныг хөгжүүлэх ажлын нэгдсэн бодлого, төлөвлөлт, шийдвэрийн төслийг албажуулж, хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Т
5 дугаар зорилтын хүрээнд	1.Төсөл хөтөлбөрийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг зохицуулалтаар хангах, шийдвэрийн төсөл боловсруулах	Мэргэжлийн салбар зөвлөлийг хуралдуулж, төсөл хөтөлбөрийн нэгдсэн зохицуулалтыг хангасан байна. Төслийн хэрэгжилт, шийдвэр баталгаажсан байна.	Х, Г, Ш
	2.Шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөрийн бодлого, төлөвлөлт, арга аргачлалыг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих.	Хэрэгжүүлсэн төсөл, үр дүн дээшилсэн байна.	Х, Г
6 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх;	Хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжсэн байна.	Г, Х
	2.Яамны удирдлага, бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, гаргаж өгөх;	Хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжсэн байна.	Г




	3.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг "Яамны хөтлөх хэргийн жагсаалт"-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах;	"Яамны хөтлөх хэргийн жагсаалт"-ын дагуу архивын нэгжийг бүрдүүлсэн байдал	Г
	4.Төрийн бус байгууллага иргэдтэй эрхэлсэн ажлын чиглэлээр хамтран ажиллах, зөвлөгөө, мэдээлэл өгөх;	Хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжсэн байна.	Т, Г, Х
	5.Газрын дотоод ажлыг хариуцан, холбогдох ажлыг цаг тухайд нь төлөвлөлт, тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн бэлтгэх тайлагнах ажлыг хариуцан зохион байгуулах.	Тайлан, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	- Багш, мэргэжлийн /0114/; - математик /0541/ ; - эрх зүй /0421/; - менежмент ба удирдахуй /0413/; - бизнес удирдлага, эрх зүйд хамаарах салбар дундын чиглэл /0488/; - нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүлзүй /0321/; - инженерчлэл, инженерийн үйлдвэрлэл /0713/; - байгалийн шинжлэх ухаан /0532/.		
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх		
Туршлага	- Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх; - хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 4-өөс доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- шинжлэх ухаан, технологийн салбарын бүтэц, тогтолцоо, стратеги, менежмент, бодлого төлөвлөлт, хэрэгжилт, зохицуулалтын асуудлыг оношлох, шалтгааныг тодорхойлох, задлан шинжлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон системийн дүн шинжилгээ хийх; - баримт бичиг боловсруулах (хууль зүйн үндэслэлтэй, асуудлыг бүрэн хамарсан, үг, үсэг, найруулгын болон	



		логикийн хувьд алдаагүй, ойлгомжтой бичих) дүгнэх чадвартай байх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг оновчтой тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - бүтээлч, санаачлагатай ажиллах, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа эерэг мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах; - мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах; - хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - бусад.
	Манлайлах	- хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх; - зарчимч, тууштай, ажил хэрэгч чанараараа хамт олондоо үлгэр дуурайл үзүүлэх; - ажлын шинэ арга барилыг нэвтрүүлж, хөгжүүлэх, бүтээлч, санаачилгатай ажиллах; - нэгжийн зорилтыг тодорхойлохдоо хамт олны оролцоог хангах, санал авах, тусгах, багийн амжилтыг үнэлэх,
	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин мөрдөж, ёс зүйн шаардлагыг биелүүлэх; - жендэрийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусад таниулах; - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, монгол бичгийн найруулгын чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, интернэт, и-мэйл зэрэг мэдээлэл харилцааны технологийг бүрэн ашиглах чадвартай байх; - төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах; - докторын зэрэгтэй бол давуу тал болно.
IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ		
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газрын дарга		



<u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> - ахлах шинжээч - 1 - шинжээч - 2 - ахлах мэргэжилтэн - 1 Нийт: 4	<u>Бусад харилцах субъект</u> - Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтан; - Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн холбогдох албан тушаалтан; - Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын холбогдох албан тушаалтан; - Иргэн, хуулийн этгээд мэргэжлийн байгууллага.
---	--

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u> <u>Албан тушаал:</u> ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА  (Т. Баясгалан) 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u> Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: Дугаар: 
---	--

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ Шийдвэрийн огноо: 2025. 03. 24 Дугаар: А/79 (тамга/ тэмдэг) ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА (И.БАТХҮҮ) 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр	
---	--